



САНАЛ ИРҮҮЛЭХ УРИЛГА

Санал ирүүлэх эцсийн хугацаа: 2014 оны 1-р сарын 6

Нийгмийн Хариуцлагын Төлөөх Дэлхий Нийтийн Түншлэл (НХТДНТ) нь хөгжиж буй орнуудад тулгамдсан засаглалын асуудлыг шийдвэрлэх зорилгоор иргэний нийгэм болон засгийн газруудыг дэмжиж, хамтран ажилладаг. Энэ зорилгыг биелүүлэхийн тулд НХТДНТ нь ил тод байдал, хариуцлагыг чангатгах ИНБ-ын нийгмийн хариуцлагын санаачлагад тогтвортой, стратегийн дэмжлэг үзүүлдэг. Энэ нь *иргэдийн хүсэлтэнд үндэслэн үйлчилгээ хүргэлтийн асуудлуудыг шийдэж, нийгмийн хүрээлэнгийн үр ашгийг нэмэгдүүлэх орчныг бий болгох* Дэлхийн банкны төрийн салбарын тоглогчид болон Дэлхий нийтийн түншлэлийн байгууллагын холбооны шууд болон хэрэгжиж буй төслүүд дээр үндэслэсэн юм. НХТДНТ-ийн дэмжлэгтэй арга хэмжээнүүд нь улсад тохируулсан аргачлалаар дамжуулан Дэлхийн банкны оролцоо ихтэй салбаруудад хэрэгжиж, засгийн газар иргэдийн хүсэлтэд хариу өгөхөд туслах юм.

НХТДНТ нь иргэдийн дуу хоолойг хүргэхэд дэмжлэг үзүүлэх, Засгийн газрыг сонсоход нь туслах, засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагууд үйл хэргээ хүлээн авсан иргэдийн хүсэлтэд нийцүүлэхэд нь туслах аргаар “завсрыг бөглөж” байна.

НХТДНТ нь 2 дахь Дэлхий нийтийн Санал ирүүлэх урилгыг зарлаж байгаадаа таатай байна. НХТДНТ нь **Монгол улсаас дараах асуудлуудын аль нэгийг тусгасан** ИНБ-уудын Нийгмийн хариуцлагын талаархи санаачлага, хөтөлбөрүүдийн саналыг хайж байна:

- ⇒ *Нийтийн байр, замын барилга, засвар үйлчилгээний төлөвлөлт, төсөвлөлт, худалдан авалт, хүлээлгэн өгөх хүртэлх бүх түвшинд хяналт тавих. Орон нутгийн засаг захиргаа, Сангийн яам, Барилга хот байгуулалтын яам болон Замын агентлагууд уг мэдээллийг ашиглан нийтийн байр, замын чанарыг сайжруулна.*
- ⇒ *Эцэг, эхийн оролцоо болон сургуулийн үр дүнгийн талаарх иргэний эрэлтийг дараах байдлаар идэвхижүүлэх боловсролын чанарт хяналт хийж, үнэлэх (i) үйлчилгээний чанарын талаарх мэдээллийн олдоцыг эцэг эх болон нийгэмд нээлттэй болгох; (ii) төрөл бүрийн аргачлалыг ашиглан тухайн мэдээллийг сургууль, нийгэмлэг, бүс, үндэсний оролцогч талуудад нээлттэй болгох; (iii) мэдээллийн түгээлтийн нөлөөллийг үнэлэх. Боловсролын яам нь боловсруулсан мэдээллийг ашиглан боловсролын үйлчилгээг аймаг, үндэсний түвшинд сайжруулна.*
- ⇒

НХТДНТ-ийн аргачлалын үзэж буйгаар бусад төрийн салбарын хүрээлэн буюу Төрийн аудитын байгууллага, хуулийн байгууллага, хөндлөнгийн захиргааны байгууллага болон бусад хяналтын байгуулагууд мөн тухайн мэдээллийг ашиглана.

Тооцогдохын тулд санал нь дараах зүйлсийг тодорхой гаргаж ирсэн байна.:

1. Төслийг туршилтын хэлбэрээс тэлж, улсыг хамарсан өргөн хүрээтэй болгоно;
2. Санал болгож буй оролцоо нь ижил төстэй зорилгоор хэрэгжиж буй санаачлагатай холбоотой. Энэ нь НХТДНТ-ийн дэмжлэгийн нэмүү өртгийг тодорхойлно;
3. Өргөн хүрээг хамарсан, хөшүүргэд суурилсан туршлагыг амжилттай биелүүлэхийн тулд бусад ИНБ-уудтай өргөн хүрээний түншлэлийг бий болгосон санал;
4. Холбогдох нийтийн хүрээлэнгийн дэмжиж буй үйл ажиллагаанд тус болох мэдээллийг боловсруулах санал.

5. *Нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх ИНБ-уудын чадамжийг “хийх-замаар-сурах” аргачлалаар дамжуулан чадамжийг бий болгох аргаар сайжруулах.*

НХТДНТ нь дараахь шинжийг агуулсан саналыг дэмжинэ:

- Нийгмийн хариуцлагийн тогтвортой, стратегийн санхүүжилтыг бий болгох 3-5 жилийн хугацаатай;
- Заасан санхүүжилтын дүн буюу \$500,000-аас \$1,000,000 ам.долларын саналын нийт төсвийг дэлгэрэнгүй гаргана. Тус дүнгээс доогуур саналыг авч үзнэ. Санхүүжилтын хүсэлт нь саналын хугацаатайгаа тохирсон байна.

Тохиромжит ИНБ: ТББ, ашгийн бус хэвлэл мэдээллийн байгууллага, хандивын байгууллага, сүсэг бишрэлийн байгууллага, мэргэжлийн байгууллага, үйлдвэрчний эвлэл, ажилчдын байгууллага, сонгуульт орон нутгийн төлөөлөгчдийн холбоо, сан, бодлого боловсруулах эрдэм шинжилгээний хүрээлэн гэх мэт ашгийн бус хуулийн этгээд.

Хүсэлт гаргагч ИНБ нь НХТДНТ-ээр (“сонгогдсон”) улс орнуудад хууль ёсны дагуу бүртгэгдсэн байх баримтыг гаргаж өгнө.

Грантад хэрхэн бүртгүүлэх, сонгогдох нөхцөл, шалгаруулалтын шалгуур, шалгаруулалтын үйл явцын талаарх дэлгэрэнгүйг НХТДНТ-ийн Анкет бөглөх гарын авлагаас харна уу.

Хэрэв та бүртгүүлэх сонирхолтой байгаа бол энэ хаягаар www.worldbank.org/gpsa орж НХТДНТ-ийн Анкет бөглөх гарын авлагыг уншиж, анкетыг татаж авна уу.

Дэлхийн банкны Монгол улс дахь оффисоос зохион байгуулж буй Танилцуулга хичээлийн талаар мэдээлэл авахыг хүсвэл доорх хаягаар холбогдоно уу:

Тина Пунцаг

tpuntsag@worldbank.org

Танилцуулга хичээл:

Огноо.

Дэлхийн банкны Монгол дахь Төлөөллөгчийн газар